



**“МОН БИЙФ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, 23.3, 23.4, 23.5, 23.6, 24 дүгээр зүйлийн 24.1, 53 дугаар зүйлийн 53.1.1, 62 дугаар зүйлийн 62.1.4 дэх хэсэг заалтуудыг удирдлага болгон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын санал хураасан дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мон Бийф” ХК-ийн ТУЗ-өөс боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсан компанийг өөрчлөх төслийг энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар уг компанийн хэлбэрийг өөрчилснийг баталсугай.
3. Өөрчлөн байгуулагдсан компанийн өмнөх ТУЗ-ийн бүрэн эрхийг 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөр дуусгавар болгож, түүний эрх залгамжлагчаар гүйцэтгэх захирал /С.Сайнбилэгт/-ыг томилсугай.
4. Компанийг өөрчлөх замаар үүссэн компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг өөрчлөх төсөлд заасны дагуу зарлан хуралдуулж, компанийн дүрэм, удирдах байгууллагыг шинэчлэн батлахыг гүйцэтгэх захирал /С.Сайнбилэгт/-д даалгасугай.
5. Өөрчлөн байгуулагдсан Мон Бийф ХК-ийн эрх, үүрэг, хариуцлага шинээр бий болсон Мон Бийф ХХК-д шилжиж байгаа болон хуулийн этгээдийн оноосон нэр, гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт ороогүй болохыг тус тус дурдсугай.
6. Өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нь өөрчлөн байгуулахын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй бол өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй болохыг дурдаж хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааг хуульд заасны дагуу зохион байгуулахыг гүйцэтгэх захирал /С.Сайнбилэгт/-д даалгасугай.
7. Энэхүү шийдвэрийг толгой компани болон холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх, бусад шаардлагатай ажиллагааг хийж гүйцэтгэхийг компанийн хуулийн зөвлөх Мөнхбаяр овогтой Номинчулуу /РД:КЮ95081405/-нд итгэмжилсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



С.САЙНБИЛЭГТ